



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Х.НЯМБААТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mjia.gov.mn,
<http://www.mjia.gov.mn>

2016. 12. 02 № 1-1/1762
танай 2016. 11. 07 -ны № 06 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөл байдал бүрэн хангагдсан эсэх талаарх Таны асуулгад Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу дараах хариуг өгч байна.

Хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж буй талаар:

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийг 2016 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс дагаж мөрдөхөөр байсныг хуулийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, хуульд заасан аргачлал, журмыг батлах зэргээр хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүднээс 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хуулийг дагаж мөрдөх хугацааг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болгосон билээ.

Хууль тогтоомжийн тухай хууль нь хууль тогтоомжийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн болон хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл явцыг хангахад ач холбогдолтой хууль болсон юм.

Энэ хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас уг хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган дараах байдлаар ажиллаж байна.

1.Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг тооцоо судалгаанд үндэслэж тодорхой үе шат, аргачлалын дагуу боловсруулах шаардлагыг тавьсан бөгөөд хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу дараах аргачлалуудыг Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлуулсан. Үүнд:

- 1/Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;
- 2/Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;
- 3/Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;
- 4/Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;
- 5/Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал;
- 6/Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.

2.Засгийн газрын тогтоолоор баталсан дээрх аргачлалуудын гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яам Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн

засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах” төсөлтэй хамтран боловсруулж гаргасан юм.

3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 44.2-т заасан хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу Хууль зүйн сайдын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/221 дугаар тушаалаар “Хууль тогтоомжийн сан бүрдүүлж, системчлэн ангилах журам”, “Хууль тогтоомжийн хувийн хэрэг бүрдүүлэх журам” батлав.

4.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан 5 аргачлалын талаар сургалт хийх 25 сургач багш нарыг Германы хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-тэй хамтран бэлтгэлээ.

5.Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан дээрх журам зэргийг нэгтгэсэн эмхэтгэлийг Германы хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ээс санхүүжүүлэн 1000 ширхэгийг хэвлүүлж, Улсын Их Хурлын бүх гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын бүх гишүүд, Улсын Их Хурлаас байгуулагддаг болон Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад хүргүүлээд байна.

6.Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалуудыг хэрхэн хэрэглэх талаар дадлага олгох сургалтыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан дор дурдсан байгууллагын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, хууль тогтоомжийн үр дагаварт үнэлгээ хийх чиг үүрэг бүхий албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа. Үүнд:

1/Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн ахлах зөвлөх болон зөвлөх, Мэдээлэл хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Төсвийн шинжилгээний болон хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нийт 56 албан хаагчдыг хамруулан 2016 оны 10 дугаар сарын 14, 17-ны өдрүүдэд 2 өдрийн сургалт;

2/Бүх яамдын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, хууль тогтоомжийн үр дагаварт үнэлгээ хийх чиг үүрэг бүхий 70 гаруй албан хаагчдыг хамруулан 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 1 өдрийн сургалт;

3/Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайд, Шадар сайдын харьяа эрхлэх асуудлын хүрээний агентлагийн 60 гаруй албан хаагчдад 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдөр 1 өдрийн сургалт;

4/Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк зэрэг Улсын Их хурлаас байгуулагддаг байгууллагын 40 гаруй албан хаагчдад 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 1 өдрийн сургалт;

Түүнчлэн 2015 оны 10 сар, 2016 оны 1 сард дээрх байгууллагуудын 50 гаруй албан хаагчдад Хууль тогтоомжийн тухай хууль болон үнэлгээ хийх аргачлалуудын талаар холбогдох сургалтуудыг хийж байсан болно.

Цаашид ч холбогдох байгууллагуудын хүсэлтийн дагуу сургалтуудыг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Тухайлбал одоогоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамд, Татварын ерөнхий газар зэрэг байгууллагуудаас хүсэлт ирсний дагуу сургалтыг нэмж зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалуудын сургалтад хамрагдсан албан хаагчдаас дараах санал, хүсэлтийг гаргаж байлаа.

1/Тухайн жилийн төсвийн тухай, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл зэрэг хууль тогтоомжийн төсөлд энэ хуульд заасан аргачлалуудын дагуу судалгаа, үнэлгээ хийх шаардлагагүй байхаар тусгах;

2/Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх асуудлууд агуулгын хувьд адил байх тул нэгтгэх;

3/Хуульд заасан аргачлалын дагуу үнэлгээ хийх субъект тодорхойгүй, үнэлгээг хууль санаачлагч өөрөө хийх нь зохимжтой эсэх, үнэлгээ хийхэд ажлын ачаалал ихээхэн нэмэгдэж байх тул холбогдох арга хэмжээ авах, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий бүтэц бий болгож, тэдгээрийг мэргэшүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэж, бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр уг хуулийг хэрэгжүүлэх.

7.Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлээр Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан эсэх талаар танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасны дагуу Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар болон хуулийг хэрэгжүүлэхэд цаашид анхаарах асуудлын талаар танилцуулж, Засгийн газраас дараах арга хэмжээ авахыг Хууль зүй дотоод хэргийн сайд болон Засгийн газрын гишүүдэд даалгасан юм. Үүнд:

1/Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хуулийн төслийг яаралтай боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад;

2/Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд эрхлэх асуудлын хүрээндээ хуульд заасан аргачлалуудын дагуу судалгаа, үнэлгээ хийх чиг үүргийг хариуцах албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тусгах, тэдгээрийг чадавхижуулж, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд.

Хуулийг хэрэгжүүлэхэд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

1.Хууль тогтоомжийн тухай хуульд дараах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлсэн бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

1/Хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлалуудын дагуу үнэлгээ хийх шаардлагагүй хууль тогтоомжийн төслийн хүрээг хуульд тодорхой тусгах. Тухайлбал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хурлаар нэн яаралтайгаар хэлэлцүүлэхээр өргөн барих хууль тогтоомжийн төсөл, тухайн жилийн төсвийн тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдэл, олон улсын гэрээ соёрхон батлах тухай зэрэг хуулийн төсөл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал батлах тухай, төсвийн гүйцэтгэл батлах тухай, үндсэн чиглэл батлах тухай /хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах үндсэн чиглэл г.м/;

2/Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.” гэж заасан.

Гэтэл дээрх хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д заасан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсний үндсэн дээр хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай талаарх гаргасан дүгнэлт, зөвлөмж нь тухайн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах үндэслэл болох талаар хуульд нэмж тусгах;

3/Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 49, 50 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх асуудал нь хуулийн 51 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх асуудалтай агуулгын хувьд давхардаж байгаа тул холбогдох өөрчлөлтийг оруулах;

4/Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш тодорхой хугацааны дараа, эсхүл зайлшгүй шаардлагатай үед хийх зохицуулалтыг тусгах;

2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-т “Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасны дагуу “Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” тушаал болон журмын төслийг 2016 оны 6 дугаар сард боловсруулж, Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Дээд Шүүх, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль сахиулахын их сургууль болон эрдэмтэн, судлаачдаас саналыг авч тусгасан ба Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан санал авахаар хүргүүлэн саналыг авч байгаа ба уг журмыг хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө эцэслэн батлах.

3.Цаашид Хууль тогтоомжийн тухай хуулийн сургалтуудыг үргэлжүүлэн зохион байгуулах.

